



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 04

Мандалговь

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. “Дундговь-Ус”ОНӨҮГазарт өөрийн хөрөнгөөр бэлтгэсэн 33,154,251.07 /гучин гурван сая нэг зуун тавин дөрвөн мянга хоёр зуун тавин нэгэн төгрөг долоон мөнгө/-ний үнэ бүхий хөрөнгийг хавсралтын дагуу данс бүртгэлдээ бүртгэж авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр бэлтгэсэн эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын данс бүртгэлд бүртгэж авахыг “Дундговь-Ус”ОНӨҮГазрын захирал Б.Отгонтөгсд даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч С.Ууганбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

0168012

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 сарын 09 өдрийн 04 дугаар тогтоолын хавсралт



Бүртгэлд авах хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	3-р ус түгээх байр	1	3,472,013.14	3,472,013.14
2	11-р ус түгээх байр	1	3,654,126.39	3,654,126.39
3	13-р ус түгээх байр	1	3,697,143.72	3,697,143.72
4	Зил-555 автомашины их засвар	1	2,572,820	2,572,820
5	Зил-4505 автомашины их засвар	1	3,432,640	3,432,640
6	Бонго жи-3 автомашины их засвар	1	3,230,800	3,230,800
7	5022-р худгийн хашаа	1	2,231,388.4	2,231,388.4
8	Конторын зуухны барилга	1	10,183,401.22	10,183,401.22
9	Конторын хайс, хаалга	1	679,918.2	679,918.2
Дүн				33,154,251.07